



Мэдээлэл
2020 оны 4-р сар | Дугаар 03



Говийн Загвар төслийн 3 дахь удаагийн мэдээллийг хүргэж байна

Говийн Загвар төслийн хоёр дахь жил Кыргызстан Улсын Исык Куль нуурын эрэгт багуудын хамтарсан уулзалтаар эхэллээ. Ингэснээр Монгол болон Кыргыз улсын багийнхан уулзаж хээрийн судалгаа, шинжилгээгээ ярилцаж, задлан шинжилгээгээ харьцуулан дүгнэж ирээдүйн төлөвлөгөөгөө хэлэлцэв. Хоёр баг уул уурхайн хууль журам, олон нийтийн харилцааг сайжруулах чиглээр засгийн газартай хамтран ажиллаж байна (2-р хуудсыг үз). Кыргызстан Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар болон Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газраас төслийг үнэлсэн. ‘Тогтвортой уул уурхай’ хөгжүүлэх чиглэлээр Монгол, Кыргызстаны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, хоёр улсын албаны хүмүүсийг Оксфордод урьж, эрчимжсэн сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах төсөлд зориулж Ариелд Оупэн Фэллоушипээс £24,000 санхүүжилт олгов. Төслийн гол өв болон үлдэх үндэсний засаглалыг бэхжүүлэх ажилд нэмэр болох зорилготой 3 сарын сүүлээр зохиогдох байсан энэ арга хэмжээ цар тахлаас шалтгаалан хойшлогдох боллоо. Төслийн баг *Төв Ази ба Монголын уул уурхайн мөчлөг* нэртэй номын төсөл, гар утасны аппликейшн боловсруулах ажил хийлээ.

Говийн Загварын Номондалай, Ариел хоёр Хил Хязгааргүй Алхам ТББ--ын Баярсайханы хамт Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газартай уулзахын өмнө 2020 оны 1 сар



ТАИС-ын Захирал Проф. Др. С. Сохаил Х. Нахви Кыргызын парламентын дэд дарга Аида Касымалиевагаас шагнал авч байгаа нь. Баруун гар талд Нээлттэй Засгийн Газрын Үндэсний Форумын Б. Сатыбеков

Говийн Загвар нь Монгол, Кыргызстан, Тажикистан улсуудад ажиллаж буй судалгааны гурван багаас бүтнэ. Илүү ихийг төслийн вэб хуудаснаас үзээрэй: <https://gobiframework.ouce.ox.ac.uk/>



Монголын Мэдээ



Монголын багийн уулзалт

“Монгол судалгаа хийх боломжоор дүүрэн. Энэ сургалт оролцогчдыг судалгааны төсөл амжилттай бичихэд нэг алхам ойртуулж өглөө.”
– Номондалай

Судалгааны тэтгэлгийн төсөл бичих сургалт



2020 оны 1 сар, МУИС

Ариел Ахэрны удирдан явуулсан судалгааны төсөл хэрхэн бичих, Британиас хэрхэн санхүүжилт олох тухай сургалтад 130 гаруй хүн оролцож, Фэйсбүүк лайваар 100 гаруй хүн үзжээ.

Уул уурхайн Нөхөн Олговрын талаарх хэлэлцүүлэг
2019 оны 12-р сарын 3. Монгол Улс, Улаанбаатар хот.

Хил хязгааргүй алхам ТББ-ын Н. Баярсайхан, Говийн Загвар төслийн баг хамтран уул уурхайн оролцогч талуудын харилцан ойлголцлыг бэхжүүлэх зорилгоор хэлэлцүүлэг зохиов. Тус хэлэлцүүлэг дээр талууд илтгэл тавьж, дугуй ширээний ярилцлага хийв. Үр дүнд нь оролцогчид нөхөн олговрын талаар нэгдсэн ойлголцолд хүрч, хамтран ажиллах урам авав. Манай баг уул уурхайн нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэлтийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, нийгэмд тархаад буй буруу ойлголтыг арилгах чиглэлээр тус хэлэлцүүлэг дээр суурилсан баримтаг кино хийхээр ажиллаж байна.



Монгол Улсын Засгийн Газрын Ажлын хэсэг

Төслийн баг Монгол Улсын Засгийн Газрын санаачилсан Бодлогын нөлөөллийн ажилд дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Тус ажлын хэсгийг ЗГХЭГ-ын Стратегийн менежмент, зохицуулалтын газрын тэргүүн С.Мөнхсүрэн ахалж, Уул уурхай геологийн стратегийн менежмент; Байгалийн баялгийн менежмент; Байгал орчин, геологи, уул уурхайн хяналт зэрэг газрын дарга нар гишүүдээр ажиллаж байгаа бөгөөд Говийн Загварын төслөөс Хил хязгааргүй алхам ТББ-ын Н.Баярсайхан, Б. Номондалай нар дэмжиж ажиллаж байна. Тус ажлын хэсгийн гол зорилго нь Нийгмийн болон эрүүл мэндийн нөлөөлөл, нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэх асуудлыг зохих хууль журамд тусгах явдал юм. Оксфордын Газар зүйн Сургууль зөвлөхөөр ажиллаж байна.

Кыргызстаны мэдээ

Төв Азид аппликейшний агуулга загварчлах

Оксфорд, Монгол, Кыргызстаны багийн гишүүд төслийн судалгаагаар хэлэлцэхээр Кыргызстаны Чон Сары-Ойд 2019 оны 9-р сард уулзав. Монгол ба Кыргызын багууд хээрийн судалгаа явуулсан нийт 6 уурхайн мэдээлэл, үр дүнг хэлэлцүүлж, аппликейшний агуулга ба хэлбэрийг хэрхэн хөгжүүлэх талаар үндсэн санааг гаргаж тохиров. Энэ ажил тус уулзалтаас хойш улам эрчимжиж байгаа бөгөөд багууд дизайнеруудтай хамтарч хэрэглэгчид мэдээллээ хуваалцахад хялбар хувилбар олох тал дээр ажилласаар байна.

2019 оны 9-р сар, Иссык-Куль нуур



Төв Азийн Их Сургуулийн 'Хөршүүдийн Урлаг: Төв Ази дахь Хилийн хөдөлгөгч хүч, Байгалийн баялаг ба хөдлөх чадвар' (2002 оны 2 сар) хуралд оролцохдоо Монголын уул уурхайн салбарын эерэг туршлагыг Кыргызстанд нэвтрүүлэх боломжийн талаар яриу. 2020 онд Засгийн газрын бодлогын хүрээлэнтэй харилцсанаар онол, практикийн шинэ санаануудыг гаргасан.

БиБиСи Кыргызын Уул уурхайг нөхөн сэргээх тухай баримтат кино - <https://youtu.be/eSEqZXhadu4>

Баримтат кинонд Чаткал, Ала-Бука ба Кассан-Сай гол дагуух газрыг нөхөн сэргээх тухай гарна. Төслийн судлаач Алмаз Чороев нутгийн иргэд, төрийн албан хаагчид ба мэргэжилтнүүдтэй уулзаж уурхай хаагдсан цагаас хойш өрнөсөн менежментийн хямралын шалтгааны талаар ярилцжээ.



Кыргызын ТВ5-д ярилцлага өгөв

КЫРГЫЗСТАН – Ерөнхийлөгчийн Тамгын Газар

Төв Азийн Их Сургуулийн (ТАИС) 2019 оны 12-р сарын 20-нд Нээлттэй Засгийн Газрын Хамтын Ажиллагааг Кыргызстанд хэрэгжүүлэхэд, тэр тусмаа уул уурхайн салбарын мэдээллийг ил болгоход оруулсан жинтэй хувь нэмрийг Кыргыз Улсын засгийн газар үнэлжээ.

Төслийн багийн цуглуулсан мэдээллээс үзээд орон нутгийн иргэд ба уул уурхайн компанийн ажилчид нөөцийн хэмжээ, ашигт малтмалын олборлолт, боловсруулалт ба экспорт, хөдөлмөр эрхлэх бололцоонууд, байгаль орчны болон эрүүл мэндийн нөлөөлөл зэргийн талаар илүү их мэдээлэл хэрэгтэй гэж дүгнэв. Баг энэ санаачилга дээр Кыргыз Улсын Засгийн Газартай үргэлжлүүлэн нягт хамтарч ажиллах болно (<https://ucentralasia.org/Resources/Item/2499/EN>).

САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭ: Британийн судалгаа ба инноваци (UKRI) нэртэй санхүүжүүлэгч байгууллага Бишкект шинээр зарлагдсан 'Мөргөлдөөний Уулзварууд' нэртэй судалгааны төсөлдөө Төв Азийн судалгааны байгууллагуудыг өрсөлдүүлэх үүднээс тусгай сургалт зохион явуулав. Говийн Загварыг амжилттай хэрэгжиж буй Дэлхийн Сорилт Судалгааны Сангийн (GCRF) нэг жишээ гэж дурджээ.


Мэдээллийг:

ahrc.ukri.org/funding/apply-for-funding/current-opportunities/grcf-conflict-intersections/grcf-conflict-intersections-pre-call-v2docx/



Эрдэм шинжилгээний хурлуудад оролцсон байдал

- ❖ CEASG Хурал: Орчин үеийн Монгол: Олон Улсын харилцаа, Уул уурхай ба Нийгэм Хронинген, Нидерланд, 2019 оны 11 сар; Бямба
- ❖ Азийн замын ажил: Ази даяарх Хятадын барьсан дэд бүтцийн төслийн соёлын, улс төрийн ба санхүүгийн амьдрал. Цюрих, Швейцар – Бямба, 2019 оны 12 сар; Бишкект, 2019 оны 9 сар; Кемел
- ❖ Төв Евразийн Судалгааны Нийгэмлэг, Вашингтон ДиСи, АНУ. 2019 оны 10 сар; Кемел
- ❖ НҮБ-ын Төлөөлөлгүй үндэстэн ба ард түмний байгууллага (UNPO) Хятадын Бүс ба Зам ба цөөнхийн эрхэд үзүүлж буй нөлөө. Берлин. 2019 оны 11 сар; Ариел
- ❖ Нэгдэл/Задрал: Говь дахь уул уурхай ба Төр Хууль ёсны байх нь. Олон улсын Антропологи ба угсаатан судлалын Нэгдэл, Польш, 2019; Ариел
- ❖ Catarpult UK: Уул уурхайн салбарт зориулсан орон зайгаар идэвхжих аппликейшнүүд . 2019 оны 11 сар; Ариел
- ❖ Дэлхийн Сорилтуудын Судалгааны Сан COMPASS Тажикистан ба Төв Ази дахь Соёлын Дипломат харилцаа . 2019 оны 9 сар; Трой
- ❖ ТАИСургууль: ‘Хөршүүд: Төв Ази дахь Хилийн хөдөлгөгч хүч, Байгалийн баялаг ба хөдлөх чадвар’. 2020; Трой
- ❖ Төв Ази дахь хулгайчдын засаг: Оксфорд, 2019 оны 10 сар; Кемел, Трой



Мэдээлэл хуваалцах гар утасны аппликейшн хөгжүүлэлт

Манай баг гар утасны аппликейшн бүтээх ажил явуулж байна. Орон нутагт уул уурхайн нөлөөнд өртөж буй Монгол, Кыргыз оршин суугчид аппликейшны гол хэрэглэгчид болох юм. Хууль эрх зүйн талаарх мэдээлэл, хэрхэн гомдол гаргах заавар болон цахим сургалт багтсан байх болно. Бид Монгол талаас хамтран ажилладаг Хүн төвтэй хадгалалт хамгаалал, Хил хязгааргүй алхам гэх мэт ТББ, судлаачидтай хамтран аппликейшний агуулгыг бүтээхээр ажиллаж байна. Туршилт зуны саруудад хийгдэ юм. Бид та бүхний санал, зөвлөгөөг хүлээж авахдаа туйлын баяртай байх болно!

Хэтийн төлөв: 2020 оны хавар/зун

- НОМ: Манай баг *Төв Ази ба Монголын уул уурхайн мөчлөг* нэртэй номын төсөл боловсруулсан бөгөөд эрдэм шинжилгээний 12 бүлэг, орон нутгийн мэргэжилтэн, малчдын дуу хоолойг тусгах ‘талбарын тэмдэглэл’ гэсэн дагалдах дэд бүлгүүдээс бүрдэх юм. Тус ном: 1) Уурхайн нээлт - уурхайн дэд бүтэц барьж байгуулах, 2) Мэдээллийн олборлолт - Орон нутаг, иргэд уул уурхайтай тулгарах, 3) Нийгэм, газар нутгийн нөхөн сэргээлт гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэх юм.



Кемел Трой хоёр ТАИС дээр болсон Иргэдийн Шинжлэх ухаан хурал дээр яриа хийж байгаа нь. Кыргызын Ерөнхийлөгч асан Роза Отунбаева урд эгнээнд байна.

Дэгдээд буй Титэмт вирусээс болоод ирэх саруудад төлөвлөөд байсан аяллууд хүлээлтийн байдалтай байна. Багийн гишүүд, хамтрагчид болон найзууддаа энэ хэцүү цаг үед эрүүл энх байхыг хүсэн ерөөе!

Ариел Ахэрн
МНБ Уорлд
сувгаар
Улаанбаатар,
Монгол Улс

